



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Нэр бүхий 6 хувьцаат компанийн
үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Сүхбаатар дүүрэг, Завхан аймгийн шүүхийн холбогдох шийдвэрүүдийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан нэр бүхий 6 /зургаа/ хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Энэхүү тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000410

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны
10 дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт



Шүүхийн шийдвэрээр татан буугдсан компаниуд

№	Компанийн оноосон нэр	Гаргасан хувьцааны тоо /ширхэгээр/	Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар
1	"Разноимпекс" ХК	1,027,921	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2007.09.28-ны өдрийн 1500 дугаар шийдвэр
2	"Монел" ХК	594,897	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2007.10.02-ны өдрийн 1589 дүгээр шийдвэр
3	"ЦАСТУ" ХК	52,672	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2007.10.11-ний өдрийн 1968 дугаар шийдвэр
4	"Чимбай" ХК	492,911	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2007.11.01-ний өдрийн 2317 дугаар шийдвэр
5	"Туул баян" ХК	150,230	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2008.12.04-ний өдрийн 2946 дугаар шийдвэр
6	"Модлог" ХК	139,954	Завхан аймгийн сум дундын 2-р шүүхийн 2006.11.20-ны өдрийн 181 дүгээр шүүгчийн захирамж